

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС

Огноо: 2023-10-25

**“ХОТЫН ДОТОРХ НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД  
ДУНД ОВРЫН АВТОБУСААР ҮЙЛЧЛЭХ”**

ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: “ДУНД ОВРЫН АВТОБУСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ”

Төслийн дугаар: ОРХОН НТ 2023/01

## ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: **“ДУНД ОВРЫН АВТОБУСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ”**

Төслийн дугаар: **ОРХОН НТ 2023/01**

1. Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар нь аймгийн Засаг даргын 2016 оны 09-р сарын 06-ны өдрийн А/440 дүгээр захирамжийн дагуу стандартын шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагыг Орхон аймгийн Баян-Өндөр суманд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний: **Ч:8 “Даниста-Урд Хабитат-Дэнж-Уртын гол” (туслах)** (Дунд оврын 4/5 автобус) чиглэлд **“ДУНД ОВРЫН АВТОБУСААР”** зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлэх тухай битүүмжилсэн төсөл ирүүлэхийг урьж байна.

2. Төслийн баримт бичиг, дэлгэрэнгүй мэдээллийг Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар Нутгийн удирдлагын ордны 2 давхар 204 тоот өрөө, 70359910, 99355333, 99352552 утсаар авна уу.

3. Төслийг 2023.10.25-ны өдрөөс 2023.11.25 хүртэлх хугацаанд нээлттэй зарлаж байна.

Төслийг **2023 оны 11-р сарын 25-ны өдрийн 10:00 цаг хүртэл аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн 204 тоот өрөөнд** хүлээн авах ба төсөлд оролцогчдыг байлцуулан **2023 оны 11-р сарын 25-ны өдрийн 10:30 цагт** нээнэ.


## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС

### НЭГ. Ерөнхий зүйл

Орхон аймгийн Засаг даргын 2023 оны 09-р сарын 11-ны өдрийн А/679 дугаар захирамжийн дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын “Даниста-Урд Хабитат-Дэнж-Уртын гол” чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжийг сонгох төсөл шалгаруулалтыг зарлаж байна.

### “ДУНД ОВРЫН АВТОБУСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ” Төслийн дугаар: ОРХОН НТ 2023/01

Ч8. “Даниста-Урд Хабитат-Дэнж-Уртын гол” чиглэл /туслах/



1.1. Төслийг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Автотээврийн тухай хууль, MNS 5012:2011 “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага”, MNS 4598:2020 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд тавих шаардлага, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/24 дүгээр тушаал, Авто тээврийн хэрэгслээр ачаа зорчигч тээвэрлэх дүрэм болон холбогдох бусад хууль, дүрэм, журам, стандартыг хангаж байгаа эсэхийг баримтлан шалгаруулна. Төсөл нь биелэгдэх бодит үндэслэлтэй, шийдвэрлэж буй асуудлууд нь үнэхээр тулгамдаж байгаа, тооцооллуудыг нарийвчлан боловсруулсан, холбогдох байгууллага албадаар баталгаажуулсан, монгол хэл дээр бичиж, уншихад

сонирхолтой ойлгомжтой, холбогдох зураглал, схем нь ойлгомжтой, мэдээлэл нь үнэн бодит байх шаардлагатай.

1.2. Төслийг хэрэгжүүлэх Техник эдийн засгийн үндэслэл, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөний нарийвчилсан схем, зураглал график, ажлын нарийвчилсан төлөвлөгөө болон дэлгэрэнгүй тайлбартайгаар, зарцуулах хөрөнгийн тооцооны хамт ирүүлнэ.

1.3. Төслийг хэрэгжүүлснээр орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил, иргэдэд үзүүлэх нөлөө, ач холбогдол, танилцуулга, тайлбарыг дэлгэрэнгүй тусгана.

1.4. Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх туршлага, урьд өмнө эрхэлж байсан ижил төстэй ажлын тухай танилцуулга, баримт материалыг тодорхой гаргана.

1.5 Төслийг өөр аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтарч хэрэгжүүлэх бол тэдгээрийн оролцоо, нийлүүлэх хувь хөрөнгө, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар албан ёсны баталгаа, тооцоо, тэдгээрийн санхүү хөрөнгийн боломжийн талаарх баталгаат мэдээллийг тусган хуудас бүрийг дугаарлаж, итгэмжлэгдсэн хүний гарын үсгийг хуудас бүр дээр зурсан байна.

1.6 Төсөлд оролцогч нь тээврийн үйлчилгээний менежментийг зөв тодорхойлсон байх, зорчигч, тээвэрлэлтийн зохион байгуулалт, төлөвлөгөөг нарийвчлан гаргах

1.7 Сонгосон чиглэл, маршрут, замналыг схем зураглал, графикаар тодорхой ойлгомжтой гүйцэтгэж, диспетчерийн хяналтыг хэрхэн хийх тухай дэлгэрэнгүй ирүүлнэ.

### **1.8 Автобусанд тавигдах шаардлага:**

Нийтийн тээврийн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд ашиглагддаг тээврийн хэрэгслийн насжилт нь Монгол улсад мөрдөгдөж байгаа MNS 5012:2011 стандартын 7.4 заалтыг /Үйлдвэрлэгдсэнээс хойш 12 жил болсон тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглоно./ баримтлах.

- Зориулалт - Нийтийн тээвэр
- Тээврийн хэрэгслийн марк, - Дунд оврын автобус
- Төрөл - 2 хаалгатай
- Даац / суудлын тоо / - 18 +1 буюу түүнээс дээш стандарт
- Хөдөлгүүрийн чадал - Байгаль орчинд ээлтэй эко, цахилгаан, евро 5 хөдөлгүүртэй
- Өнгө - Ижил өнгөтэй байх /Ж нь: шар/
- Дугуй - Стандартын шаардлага хангасан байх
- Зорчигч зогсоогоор явахад зориулагдсан аюулгүйн бариулаар бүрэн тоноглогдсон, хажуу талдаа салхивч, цонх, хөшигтэй байх.
- Зорчигчийн заалны гэрэлтүүлэх, дулаацуулах систем, автобусны доторх тоноглол бүрэн, жирэмсэн хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан суудалтай.
- Техникийн хувьд дэвшилттэй, бүрэн бүтэн, хийц загвар өнгө үзэмж сайн, хэмнэлттэй шатахуун, тосолгооны материал, ашиглалтын бусад материал бага зарцуулдаг, хүн ам, хүрээлэн буй орчинд аюулгүй, экологийн шаардлага хангасан байх.

- Техникийн үйлчилгээ, тохиргоог бүрэн хийсэн, техникийн хяналтын үзлэг оношилгоонд орж, шаардлага хангасан, замын хөдөлгөөнд оролцох эрхийн гэрчилгээ авсан байх.
- Автотээврийн хэрэгслийн тэвш, бүхээг, чингэлэг, гишгүүр, шат, бариул, суудал, түшлэг нь тээвэрлэлтийн нөхцөл, стандартын шаардлагыг бүрэн хангасан байх.
- Жолооч тусгаарлах кабинтай, заалны мэдээлэх хэрэгсэл бүрэн ажиллагаатай байх
- Зогсоол буудлыг зарлах чанга яригч, радио, магнитофон, техник хэрэгсэл бүрэн
- Тээврийн хэрэгслийн техникийн иж бүрдэл бүрэн байх /эмийн сан, галын хор, дугуйн ивүүр, ослын тэмдэг г.м/
- Автобусанд сүүлийн үеийн шаардлагад нийцсэн ухаалаг хяналтын систем суурилуулсан байх

1.14. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн санал, санаачилга, хөтөлбөр, төлөвлөгөөг тусгах.

1.15. Мэргэжлийн баг, хүний нөөц бүрдүүлэлтийн мэдээлэл /удирдлага, шалгах механик, инженер техникийн ажилтан, диспетчер, тээвэр зохицуулагч, жолооч, кондуктор, ня-бо, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, ...../

1.17. Болзошгүй гэнэтийн байгалийн гамшиг, цаг агаарын таагүй нөхцөлд ажиллах эрсдэлийн менежмент, эрсдэлийн төлөвлөгөө, зохион байгуулалтын хэлбэр, техник хэрэгслийн техникийн бэлэн байдал, эвдрэл гэмтэл гарсан үед авах арга хэмжээ

1.18. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх этгээдийн төсөл шалгаруулалт явуулах бэлтгэл ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс хариуцан гүйцэтгэх бөгөөд төсөл шалгаруулах, үнэлгээ хийх ажлыг аймгийн Засаг даргын 2023 оны А/679 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг шалгаруулна.

1.19. Ажлын хэсгийн үнэлгээгээр шалгарсан оролцогч нь хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгэх үүрэг хүлээж зорчигч тээвэрлэлтийн гэрээ байгуулан, зорчигч тээвэрлэлтийг ирүүлсэн төслийн дагуу гүйцэтгэнэ.

### **Хоёр. Санхүүгийн чадвар**

2.1.Төсөлд оролцогч нь санхүү, эдийн засгийн хувьд чадвартай гэдгээ нотлох баримт бичиг /хоёр жилийн санхүүгийн аудитаар баталгаажуулсан тайлан/ ирүүлнэ.

2.2.Татварын байгууллагын тодорхойлолтыг төслийн хугацаанд ирүүлнэ.

2.3.Гэмт хэрэг, маргаан, зөрчил гаргаж байсан эсэхийг тодорхойлох бичиг баримтыг төслийн хугацаанд эх хувиар ирүүлнэ.

### **Гурав. Эрх бүхий төслийн оролцогч**

3.1.Төслийн урилга нь эрх бүхий оролцогч бүрт нээлттэй. Гадаадын иргэнийг оролцуулахгүй. Дараах тохиолдолд төсөлд оролцогч (түншлэлийн гишүүн бүрд нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:

3.2. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэн, үйл ажиллагаа явуулж байсан боловч

холбогдох стандартын шаардлага хангаж ажиллаагүй нь удаа дараагийн шалгалтаар илэрсэн, зам тээврийн зөрчил, осол гаргаж байсан, гэмт хэрэгт холбогдож байсан нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон.

3.2.1.Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа,

3.2.2.Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;

3.2.3.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь төсөл зарлан, зохион байгуулагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг;

3.2.4.Сүүлийн 3 жилийн хугацаанд төсөл шалгаруулалт, худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;

3.2.5.Төсөлд оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;

3.2.6.Илт худал мэдээлэл бүхий төсөл ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;

3.2.7.Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;

3.2.8.Төсөлд оролцогч нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг төслийн зураг төсөл,

техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах зөвлөхөд нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой бол;

3.2.9.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд бүтэц зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол /Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд зааснаар төр ашгийн төлөө үйл ажиллагааг зөвхөн төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр дамжуулан явуулахаар заасан тул эдгээрээс бусад төрийн байгууллага, албан газар төсөлд оролцох эрхгүй/.

3.3.Төсөлд оролцогч 3.2.1-3.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг

захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу төсөлд оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.

### **Дөрөв. Төсөлд оролцогчийн чадвар**

4.1. Хууль эрх зүйн статус, бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны чиглэл, буюу үүсгэн байгуулагдсаныг тодорхойлох албан ёсны баримт бичгийн эхээс хийсэн хуулбар, төсөлд оролцогчийн өмнө үүрэг хүлээж түүнийг төлөөлж төсөлд гарын үсэг зурах этгээдийн албан ёсны итгэмжлэл.

(б) Тухайн үйлчилгээтэй шинж чанар болон хэмжээгээрээ ижил төстэй үйлчилгээ гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэсэн болон одоо хийж байгаа тухайг захиалагч болон түүнтэй холбоо барьж болох нэр, хаяг, төрөл хэмжээ зэрэг гэрээний дэлгэрэнгүй мэдээллийн хамт жил тус бүрээр гаргаж ирүүлэх.

(в) Төслийг хэрэгжүүлэхэд санал болгож буй удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл

(г) Захиалагч тухайн төсөлд оролцогчийн харилцагч банкнаас түүний талаар тодорхойлолт хүсэхэд татгалзахгүй тухай зөвшөөрсөн албан бичиг

4.2. Төсөлд оролцогч гэрээ байгуулах эрх олж авахын тулд дор дурдсан чадварын доод шалгуурыг хангасан байна:

(а) Монгол улсын **MNS 5012:2011 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ.**

**Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага** стандартад заасны дагуу барилга байгууламж нь өөрийн эзэмшлийн байна. Түрээсийн гэрээгээр ажиллуулах бол гэрээг хавсаргах.

### **Тав. Төсөлд оролцогч нэг этгээд нэг төсөл ирүүлэх**

5.1. Нэг төсөлд оролцогч дангаараа, эсхүл түншлэлийн гишүүн болж төсөл шалгаруулалтад оролцож байгаа бол зөвхөн нэг төсөл ирүүлнэ. Төсөлд оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш төсөл ирүүлсэн, эсхүл ирүүлэхэд оролцсон бол түүний ирүүлсэн бүх төслөөс татгалзана. Энэ нөхцөл нь туслан гүйцэтгэгчийн хувьд болон хувилбарт төсөл ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд тус тус хамаарахгүй.

### **Зургаа. Төсөл шалгаруулалтад оролцох зардал**

6.1. Төсөлд оролцогч нь түүний төслийг бэлтгэх болон ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө хариуцах бөгөөд ямар ч нөхцөлд эдгээр зардалтай холбогдох үүрэг хариуцлагыг захиалагч хүлээхгүй.

### **Долоо. Үйлчлэх чиглэлтэй танилцах**

7.1. Шаардлагатай үйлчилгээг үзүүлэх байршил, талбай болон чиглэл, зорчигч урсгалын талаар судалгаа хийж төсөл бэлтгэх, гэрээ байгуулахад шаардлагатай байж болох бүх мэдээллийг төсөлд оролцогч олж авч ашиглаж болно. Чиглэлтэй танилцах зардлыг төсөлд оролцогч өөрөө хариуцна.

### **Найм. Төслийн баримт бичгийн агуулга, дараалал**

- 8.1. Төслийг битүүмжлэн Үндсэн эх хувийг дугтуйнд хийж ирүүлэх
  - 8.2. Хуудас бүрд итгэмжлэгдсэн хүн гарын үсэг зурах
  - 8.3. Байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга
  - 8.4. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
  - 8.5. Аудитаар баталгаажуулсан сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан
  - 8.6. Санхүүгийн чадавхыг тодорхойлсон банкны тодорхойлолт
  - 8.7. Ижил төстэй ажлын талаарх мэдээлэл
  - 8.8. Удирдлага, ажилтнуудын дэлгэрэнгүй танилцуулга, мэргэжлийн дипломын хуулбар
  - 8.9. Хууль, шүүхийн байгууллагаас гэмт хэрэгт холбогдож байсан эсэх тодорхойлолт
  - 8.10. Татварын байгууллагын тодорхойлолт
  - 8.11. ТЭЗҮ, үр ашгийн тооцоог хийсэн байдал
  - 8.12. Чиглэлд үйлчлэх маршрутын зураглал, төлөвлөгөө, график, схем, цагийн давтамж
  - 8.13. Төсөл хэрэгжүүлж эхлэх хугацааг тодорхой заах
  - 8.14. Инженер техникийн ажилтнууд, жолооч нарын хүрэлцээ, хүний нөөцийн бүрдэлт
  - 8.15.Тээврийн хэрэгслийг хадгалах, засварлах, угаах газар, жолооч, кондуктор, ажилтнуудын ажил, амралтын дэглэм, амралтын байр, эрүүл мэнд, нийгмийн даатгалын төлөлт, хамруулах байдал
  - 8.16. Цаашид төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар санхүүгийн чадвар, менежмент, зохион байгуулалт, ажлын төлөвлөгөө
  - 8.17.Байгууллагын үйл ажиллагааны туршлагын талаарх мэдээлэл
  - 8.18.Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, аваар ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, шинэлэг санаа
  - 8.19. Диспетчерийн хяналт хэрхэн хийх тухай дэлгэрэнгүй бичих. Сүүлийн үеийн техник технологи ашиглах байдал /GPS, зорчигчийн card, камер, диспетчерийн хяналтыг хэрхэн хийх талаар/
  - 8.20.Төсөлд оролцогч нь төслийн баримт бичиг дахь бүх зааварчилгаа, маягтууд, нөхцөлүүд болон тодорхойлолтуудыг шалгаж нягтална.
  - 8.21.Бусад шаардлагатай бусад нэмэлт мэдээ, мэдээллээ тусгах.
- Төслийн баримт бичигт ирүүлэхийг шаардсан бүх мэдээллийг дутуу ирүүлэх, эсхүл төслийн баримт бичгийг хангаж чадаагүй төсөл ирүүлэх нь төсөлд оролцогчийн эрсдэлд хамаарах ба энэ нь түүний төслөөс татгалзах үндэслэл болж болно.

### **ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС**